

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2023/30/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2023.02.17	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: <a href="mailto:tseenyama@audit.gov.mn">tseenyama@audit.gov.mn</a> Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: <a href="mailto:Narangerelb@audit.gov.mn">Narangerelb@audit.gov.mn</a> Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Албан шаардлага .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584  
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/108

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж

тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>114,131,342.21</b>	<b>301,996,658.93</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	180,968,448.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	180,968,448.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	180,968,448.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	180,968,448.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	114,131,342.21	121,028,210.93
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	74,164,002.97	72,965,852.97
35110	Тусгай зориулалттай материал	73,356,252.97	72,717,852.97
35130	Эм боох материал	807,750.00	248,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	39,967,339.24	48,062,357.96
35420	Аж ахуйн материал	28,547,137.24	29,292,637.24
35440	Түлш, шатах тослох материал	2,524,000.00	3,456,000.00
35460	Хүнсний материал	139,402.00	31,780.00
35470	Бусад хангамжийн материал	8,756,800.00	15,281,940.72
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,010,213,093.38</b>	<b>1,056,774,798.79</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,010,213,093.38	1,056,774,798.79
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	975,839,093.38	1,022,400,798.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	948,665,873.78	948,665,873.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	-127,006,770.96	-173,894,156.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,000,000.00	18,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9,000,000.00	-12,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	143,831,452.45	252,527,494.45
39206	Хуримтлагдсан элэгдэл	-86,343,603.22	-108,249,846.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	105,363,938.26	124,516,038.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	-51,237,877.19	-63,423,742.64
39217	Ном	33,566,080.26	36,259,138.26
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	34,374,000.00	34,374,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	34,374,000.00	34,374,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,124,344,435.59</b>	<b>1,358,771,457.72</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>50,000.00</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	50,000.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	50,000.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	50,000.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,124,294,435.59</b>	<b>1,358,771,457.72</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,124,294,435.59	1,358,771,457.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	433,663,308.00	433,663,308.00
51101	Өмч: - төрийн	433,663,308.00	433,663,308.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	202,204,946.17	436,681,968.30
51210	Өмнөх үеийн үр дүн	202,204,946.17	202,204,946.17
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	234,477,022.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	488,426,181.42	488,426,181.42
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,124,344,435.59</b>	<b>1,358,771,457.72</b>

/төгрөгөөр/

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>808,111,344.36</b>	<b>1,344,599,390.72</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,692,633.36</b>	<b>116,146,720.72</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	18,692,633.36	116,146,720.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	2,099,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,969,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	130,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>75,316,611.00</b>	<b>1,228,452,670.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	1,079,550,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,079,550,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	714,102,100.00	00.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	33,430,477.00	48,562,170.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,430,477.00	48,562,170.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	41,886,134.00	100,340,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,886,134.00	100,340,400.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>841,549,108.14</b>	<b>1,110,122,368.59</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>841,549,108.14</b>	<b>1,110,122,368.59</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	790,558,513.14	970,422,403.59
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	555,121,037.00	674,206,881.00
210101	Үндсэн цалин	555,121,037.00	459,575,152.00
210102	Нэмэгдэл	00.00	146,982,482.00
210104	Урамшуулал	00.00	30,634,452.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	37,014,795.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	71,731,500.00	83,615,065.00
210201	Тэтгэврийн даатгал	68,585,800.00	57,773,682.00
210202	Тэтгэмжийн даатгал	778,800.00	6,748,368.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	623,000.00	5,520,836.00
210204	Ажилгүйдлийн даатгал	155,800.00	1,227,531.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,588,100.00	12,344,648.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	42,332,134.00	55,226,911.00
210301	Гэрэл, цахилгаан	5,636,134.00	7,215,111.00
210302	Түлш, халаалт	36,696,000.00	47,516,000.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	495,800.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,230,686.03	22,648,050.00
210401	Бичиг хэрэг	1,553,400.00	3,008,950.00
210402	Тээвэр, шатахуун	2,871,400.00	5,512,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,841,100.00	00.00
210404	Ном, хэвлэл	148,000.00	56,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	108,100.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,787,650.00	6,626,000.00
210408	Бараа материал акталсны зардал	13,921,036.03	7,444,500.00
2105	<b>Нормативт зардал</b>	15,195,600.00	16,139,552.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,499,850.00	806,250.00
210502	Хоол, хүнс	11,832,750.00	15,333,302.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	863,000.00	00.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,149,000.00	1,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	385,600.00	00.00
210604	Урсгал засвар	3,763,400.00	1,000,000.00
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	539,800.00	799,000.00
210702	Дотоод албан томиллолт	539,800.00	799,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,385,501.00	9,955,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,885,501.00	1,969,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	7,986,000.00

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	74,873,255.11	106,831,644.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	315,000.00	13,359,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,548,000.00	9,492,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	73,010,255.11	83,979,494.59
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	50,990,595.00	139,699,965.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	47,027,026.00	139,635,470.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,544,400.00	59,922,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,318,456.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,623,270.00	48,562,170.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,540,900.00	31,151,300.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	64,495.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	64,495.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,963,569.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,963,569.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-33,437,763.78</b>	<b>234,477,022.13</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	53,992.50	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	53,992.50	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-53,992.50	00.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-33,491,756.28</b>	<b>234,477,022.13</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>789,418,711.00</b>	<b>1,230,421,970.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>1,969,300.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	1,969,300.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	1,969,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,969,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>789,418,711.00</b>	<b>1,228,452,670.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	1,079,550,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,079,550,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	714,102,100.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	33,430,477.00	48,562,170.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	33,430,477.00	48,562,170.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	41,886,134.00	100,340,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	41,886,134.00	100,340,400.00

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>759,138,711.00</b>	<b>1,027,537,102.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>759,138,711.00</b>	<b>1,027,537,102.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>703,895,816.00</b>	<b>887,837,137.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>555,114,379.00</b>	<b>670,874,653.00</b>
210101	Үндсэн цалин	379,837,379.00	448,188,677.00
210102	Нэмэгдэл	94,532,400.00	154,263,344.00
210104	Урамшуулал	42,630,900.00	30,807,838.00
210105	Гэрээт ажлын хөлс	38,113,700.00	37,614,794.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>71,731,500.00</b>	<b>86,997,293.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	53,292,900.00	60,080,386.16
210202	Тэтгэмжийн даатгал	4,622,100.00	7,374,987.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,647,700.00	5,699,929.70
210204	Ажилгүйдлийн даатгал	924,400.00	1,258,352.48
210205	Эрүүл мэндийн даатгал	9,244,400.00	12,583,637.55
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,886,134.00</b>	<b>56,158,911.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,953,934.00	5,553,176.00
210302	Түлш, халаалт	35,832,200.00	50,107,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	498,735.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,793,200.00</b>	<b>00.00</b>
210401	Бичиг хэрэг	1,422,900.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,600,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,369,100.00	00.00
210404	Ном, хэвлэл	265,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,240,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,895,900.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>15,778,352.00</b>	<b>15,225,680.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,524,600.00	00.00
210502	Хоол, хүнс	7,749,952.00	15,225,680.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,503,800.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,477,500.00</b>	<b>1,000,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	687,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,790,500.00	1,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>539,800.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	539,800.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,223,951.00</b>	<b>9,955,300.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,483,951.00	1,969,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	7,986,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,351,000.00</b>	<b>47,625,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	35,644,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,351,000.00	11,980,850.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55,242,895.00</b>	<b>139,699,965.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>51,279,326.00</b>	<b>139,635,470.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,796,700.00	59,922,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,318,456.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,623,270.00	48,562,170.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,540,900.00	31,151,300.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>64,495.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	64,495.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,963,569.00</b>	<b>00.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,963,569.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>30,280,000.00</b>	<b>202,884,868.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>30,280,000.00</b>	<b>21,916,420.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>30,280,000.00</b>	<b>21,916,420.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>30,280,000.00</b>	<b>21,916,420.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	30,280,000.00	21,916,420.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-30,280,000.00</b>	<b>-21,916,420.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>180,968,448.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>180,968,448.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	235,696,702.45	1,157,786,191.87
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	235,696,702.45	1,157,786,191.87
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-33,491,756.28	-33,491,756.28
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	202,204,946.17	1,124,294,435.59
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	202,204,946.17	1,124,294,435.59
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	202,204,946.17	1,124,294,435.59
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	234,477,022.13	234,477,022.13
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	433,663,308.00	488,426,181.42	436,681,968.30	1,358,771,457.72

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,181,859,800.00	1,000,826,857.00	181,032,943.00	84.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,181,859,800.00	1,000,826,857.00	181,032,943.00	84.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,088,154,100.00	909,753,557.00	178,400,543.00	83.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	829,150,500.00	670,874,653.00	158,275,847.00	80.9
210101	Үндсэн цалин	583,807,500.00	448,188,677.00	135,618,823.00	76.8
210102	Нэмэгдэл	177,485,100.00	154,263,344.00	23,221,756.00	86.9
210104	Урамшуулал	30,241,300.00	30,807,838.00	-566,538.00	101.9
210105	Гэрээт ажлын хөлс	37,616,600.00	37,614,794.00	1,806.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,444,500.00	86,997,293.00	17,447,207.00	83.3
210201	Тэтгэврийн даатгал	71,022,500.00	60,080,386.16	10,942,113.84	84.6
210202	Тэтгэмжийн даатгал	8,355,400.00	7,374,987.11	980,412.89	88.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,684,400.00	5,699,929.70	984,470.30	85.3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,671,100.00	1,258,637.55	412,462.45	75.3
210205	Эрүүл мэндийн даатгал	16,711,100.00	12,583,637.55	4,127,462.45	75.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,221,200.00	56,158,911.00	62,289.00	99.9
210301	Гэрэл, цахилгаан	5,554,200.00	5,553,176.00	1,024.00	100.0
210302	Түлш, халаалт	50,167,000.00	50,107,000.00	60,000.00	99.9
210303	Цэвэр, бохир ус	500,000.00	498,735.00	1,265.00	99.7
2105	Нормативт зардал	17,781,600.00	15,225,680.00	2,555,920.00	85.6
210502	Хоол, хүнс	17,781,600.00	15,225,680.00	2,555,920.00	85.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,956,800.00	9,955,300.00	1,500.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,969,300.00	1,969,300.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,987,500.00	7,986,000.00	1,500.00	100.0

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>69599500.00</b>	<b>69541720.00</b>	<b>57,780.00</b>	<b>99.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,618,200.00	57,560,870.00	57,330.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,981,300.00	11,980,850.00	450.00	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>93705700.00</b>	<b>91073300.00</b>		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>93,705,700.00</b>	<b>91,073,300.00</b>	<b>2,632,400.00</b>	<b>97.2</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,554,400.00	59,922,000.00	2,632,400.00	95.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	24,318,456.00	-24,318,456.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	4,623,270.00	-4,623,270.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,151,300.00	31,151,300.00	0.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,181,859,800.00</b>	<b>1,181,859,800.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,079,550,100.00</b>	<b>1,079,550,100.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,079,550,100.00	1,079,550,100.00	0.00	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>100,340,400.00</b>	<b>100,340,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
132001	Орон нутгийн төсвөөс	100,340,400.00	100,340,400.00	0.00	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,969,300.00</b>	<b>1,969,300.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,969,300.00	1,969,300.00	0.00	100.0
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>180,968,448.00</b>	<b>-180,968,448.00</b>	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>52.00</b>	<b>52.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	32.00	32.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	0.00	100.0
620004	Гэрээт ажилтан	09.00	09.00	0.00	100.0
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>489.00</b>	<b>489.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>489.00</b>	<b>489.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>33,430,477.00</b>	<b>48,562,170.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>33,430,477.00</b>	<b>48,562,170.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,488,751.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,488,751.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,488,751.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,941,726.00</b>	<b>48,562,170.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>28,941,726.00</b>	<b>48,562,170.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,318,456.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,623,270.00	48,562,170.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>33430477.00</b>	<b>48,562,170.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>33,430,477.00</b>	<b>48,562,170.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,430,477.00	48,562,170.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь “Эх хэлээрээ зөв сайхан бичдэг, бусдыг хүндэлдэг, хөдөлгөөний эвсэлтэй хамт олон болгох” эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг тодорхойлжээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Сангийн сайдын 2018 оны тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын жишиг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 234,427.0 мянган төгрөг буюу 20.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
А	1	2	3	4	5	6
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	114,131.3	10.2%	301,996.7	22.2%	187,865.3	164.6%
Мөнгөн хөрөнгө	-	0.0%	180,968.4	13.3%	180,968.4	0.0%
Авлага	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	114,131.3	10.2%	121,028.2	8.9%	6,896.9	6.0%
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,010,213.1	89.8%	1,056,774.8	77.8%	46,561.7	4.6%
Үндсэн хөрөнгө	1,284,251.3	114.2%	1,414,792.5	104.1%	130,541.2	10.2%
Хуримтлагдсан элэгдэл	(274,038.3)	-24.4%	(358,017.7)	-26.3%	(83,979.5)	30.6%
<b>Нийт хөрөнгө</b>	1,124,344.4	100.0%	1,358,771.5	100.0%	234,427.0	20.9%
Өр төлбөр	50.0	0.0%	-	0.0%	(50.0)	-100.0%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,124,294.4	100.0%	1,358,771.5	100.0%	234,477.0	20.9%
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	1,124,344.4	100.0%	1,358,771.5	100.0%	234,427.0	20.9%

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь үндсэн дансны үлдэгдэл 180,968.4 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 121,028.2 мянган төгрөг болж 6,896.9 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал данс 745.5 мянга, бусад хангамжийн материал данс 6,525.1 мянга, түлш шатах тослох материал данс 932.0 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,414,792.5 мянган төгрөг болж 130,541.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 21,916.4 мянга, Боловсрол, Шинжлэх ухааны газрын 2022.12.26-ны өдрийн 516 дугаар албан бичгээр 27,285.6 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, мөн 2,693.1 мянган төгрөгийн ном, 77,453.1 мянган төгрөгийн өртөг бүхий тавилга, тоног төхөөрөмжийг шилжүүлэн авч, НҮБ-ийн хүүхдийн сангаас 1,193.0 мянган төгрөгийн ус цэвэршүүлэгчийг хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,358,771.5 мянган төгрөг болж 234,477.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,113,182.4 мянган төгрөгөөр зарцуулахаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 68,677.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,181,859.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1,079,550.1 мянга, орон нутгийн төсвөөс 100,340.4 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 1,969.3 төгрөгийн эх

үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,034,257.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,000,826.9 мянган төгрөг буюу 84.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 158,275.8 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 17,447.2 мянга, нормативд зардлыг 2,555.9 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	<b>71802 Ерөнхий боловсрол</b>	<b>1,181,859,800.00</b>	<b>1,000,826,857.00</b>	<b>181,032,943.00</b>	<b>84.7%</b>
2	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	3,195,000.00	3,194,400.00	600.00	99.9%
3	80312 Сургалт семинар	1,597,500.00	1,597,500.00	0.00	100.0%
4	81605 Эрүүл мэндийг дэмжих	3,674,300.00	3,674,000.00	300.00	99.9%
5	81801 үдийн цай хөтөлбөр	62,554,400.00	59,922,000.00	2,632,400.00	95.8%
6	81806 Дотуур байрны үйлчилгээ	32,903,500.00	26,978,832.00	5,924,668.00	82.0%
7	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	16,485,000.00	16,476,420.00	8,580.00	100.0%
8	81823 Боловсролын байгууллагын багш,	7,188,800.00	7,155,200.00	33,600.00	99.5%
9	81834 Боловсролын стандарт, сургалтын	807,553,900.00	645,377,354.00	162,176,546.00	80.0%
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	144,397,700.00	134,205,946.00	10,191,754.00	92.9%
11	81848 Сурах бичгийн түрээс	1,969,300.00	1,969,300.00	0.00	100.0%
12	80112 Нийтлэг үйлчилгээ	100,340,400.00	100,275,905.00	64,495.00	99.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд дээд шатны төсөв захирагчаас 48,562.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс дэмжлэг үзүүлэхэд 48,562.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээ сарын 16-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 841,549.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,623.2 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,836.3 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хуулийн хэрэгжилтийг шалгахад тус байгууллага нь 2022 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 15,272.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь тайлант онд 1 тонн нүүрсний тээврийн зардал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 1,127,175.1 мянган төгрөгийн 42 мэдээлэл, 6.4.8-д “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл”-д заасан 31,151.3 мянган төгрөгийн 72 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Харин хуулийн 6.4.3-д “Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл”-д заасан 62,554.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг мэдээлээгүй, 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 81,775.9 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээг, 5,440.0 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг хугацаа хоцроож, 48,562.2 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээ, 21,897.9 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээг огт мэдээлээгүй, 6.4.8-д “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл”-д заасан 63,902.1 мянган төгрөгийн 2 мэдээллийг мэдээлээгүй, мөн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол нийлүүлэх гэрээ, цахим худалдан авалтын гэрээ зэргийг байршуулаагүй байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж аудитаар 48,030.7 мянган төгрөгийн 6 зөвлөмж хүргүүлснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2022.05.30-ний өдрийн 21 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	0	0	0	0	
Албан шаардлага	0	0	0	0	
Зөвлөмж	6	48,030.7	6	48,030.7	100
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>48,030.7</b>	<b>6</b>	<b>48,030.7</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол "Хоолны зардлын норматив тогтоох тухай"-ын 4-т " Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байхыг БСУШУС, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасан ба тус сургуулийн дотуур байрны хоол хүнсний зардлаас 2,555.9 мянга, үдийн хоолны зардал 2,632.4 мянган төгрөг хэмнэгдсэн байхад төсөвт төвлөрүүлээгүй ба харилцах дансанд үлдэгдлээр байна. Энэ асуудлыг Боловсролын ерөнхий газрын хэмжээнд нэгтгэн анхаарч авч үзэх шаардлагатай байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,992.1 мянган төгрөгийн 6 зөрчил<sup>1</sup> илэрснээс зөрчлийг арилгах 8,290.2 мянган төгрөгийн 3 албан шаардлага, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 6,701.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

##### 5.1 Албан шаардлага

5.1.1 Тайлант хугацааны нөхөн хангалтын зардлаас цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй "Баялаг-Эрдэнэ" ХХК-иас 5900.0 мянган төгрөгийн өртөг бүхий 1 зөөврийн компьютер худалдан авсан байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх заавар"-ын 2.2.6 "Сургууль, цэцэрлэг нь Ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгч байгууллагаас холбогдох журмын дагаа худалдан авах ажиллагааг бие даан зохион байгуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан журмын дагуу санал авч, ач холбогдлоор нь эрэмбэлж, ерөнхий гэрээ байгуулсан аж ахуйн нэгжээс худалдан авч байх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.3-д заасан 62,554.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг мэдээлээгүй, 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 81,775.9 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээ, 5,440.0 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг хугацаа хоцроож, 48,562.2 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээ, 21,897.9 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээг мэдээлээгүй байна. Мөн цахилгаан, дулаан, хүүхдийн хоол хүнс, үдийн цай нийлүүлэх гэрээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3 "Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан", 6.4.5 "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5-д заасан 133,014.1 мянган төгрөгийн 6 гүйлгээ, бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гэрээнүүдийг шилэн дансны цахим хуудаст бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

5.1.3 Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих арга хэмжээний зардлаас Хас-Ойл ХХК руу 410.2 мянган төгрөгийн шатахуун, 1980.0 мянган төгрөгийг Гурванбулаг сум явж туршлага солилцох тээврийн зардал, сургалтын материалд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар баталсан “Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ын 5.2.2 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих арга хэмжээний зардлыг зарцуулахдаа хууль журмыг зөрчдөг байдлыг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 1,007.9 мянган төгрөгийн 5 гүйлгээг и баримтгүй харилцагч байгууллагын дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6. “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5. Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” заалтуудыг мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд халаалтын зардлаас 1659.0 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардалд, цэвэр бохир усны зардлаас 235.0 мянган төгрөгийн өртөг бүхий усны хоолойн төлбөрийг төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчиж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулдаг байдлыг таслан зогсоож, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөж ажиллах.

### 3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Бараа үйлчилгээний зардлаас хуучин захирал асан Насантогтоход 3800.0 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчиж, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулдаг байдлыг таслан зогсоож, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 1,007.9 мянган төгрөгийн 5 гүйлгээг и баримтгүй шилжүүлсэн байна.	1	1,007.9					1	1,007.9
Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих арга хэмжээний зардлаас Хас-Ойл ХХК руу 410.2 мянган төгрөгийн шатахуун, 1980.0 мянган төгрөгийг Гурванбулаг сум руу туршлага солилцох тээврийн зардал, сургалтын материалд зарцуулсан байна.	1	2,390.2			1	2,390.2		
Тайлант хугацааны нөхөн хангалтын зардлаас цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй "Баялаг-Эрдэнэ" ХХК-иас 5900.0 мянган төгрөгийн өртөг бүхий 1 зөөврийн компьютер худалдан авсан байна.	1	5,900.0			1	5,900.0		
Тайлант хугацаанд халаалтын зардлаас 1659.0 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардалд, цэвэр бохир усны зардлаас 235.0 мянган төгрөгийн өртөг бүхий усны хоолойн төлбөрийг төлсөн байна.	1	1,894.0					1	1,894.0
Бараа үйлчилгээний зардлаас хуучин захирал асан Насантогтоход 3800.0 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон байна.	1	3,800.0					1	3,800.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>14,992.1</b>			<b>2</b>	<b>8,290.2</b>	<b>3</b>	<b>6,701.9</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

**Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой.								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.3-д заасан 62,554.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг мэдээлээгүй, 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 81,775.9 мянган төгрөгийн орлогын 3 гүйлгээ, 5,440.0 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг хугацаа хоцроож, 48,562.2 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээ, 21,897.9 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээг мэдээлээгүй байна. Мөн цахилгаан, дулаан, хүүхдийн хоол хүнс, үдийн цай нийлүүлэх гэрээг байршуулаагүй байна.	1	0			1	0		
Дүн	1	0			1	0		

-----oO-----